



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 4/45

Хажуу шинэ ус

Мэргэжилтний баг ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 36 дугаар зүйл, Архидан согтууруулахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 83 дугаар тогтоол аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3-ийн Амар тайван, аюулгүй нийгэм бүлгийн 4.3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Иргэдийн сайн дурын үндсэн дээр байгуулагдан архинд донтох өвчнийг эдгэрүүлэх болон гэр бүлийн бусад гишүүдийг эдгэрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж, тодорхой үр дүнд хүрч буй Архичид аминчлахуй (АА) болон Давхар хамаарлын бүлэг (Ал-Анон), Давхар хамааралтай хүүхдүүдийн бүлэг (Алатен), Архичдын болон асуудалтай гэр бүлд өссөн насанд хүрсэн хүмүүсийн бүлэг (АСА) нөхөрлөлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор сумын хэмжээнд ажиллах чиг үүрэг бүхий "Мэргэжилтний баг"-ийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Архичид аминчлахуй болон давхар хамаарлын бүлгүүдийн үйл ажиллагаа явуулж буй орон байрны багтаамж, нөхцөл байдлыг сайжруулах, цаашид шинээр үүсэн бий болж байгаа бүлгүүд уулзалт, ярилцлага явуулах орон байртай болох санал хүсэлтийг бодлогын хүрээнд дэмжиж ажиллах.

3.Аймгийн хэмжээнд ажиллах мэргэжилтний багийн үйл ажиллагааны зардлыг тухай бүр орон нутгийн төсвийн нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Ганбат)-д зөвшөөрсүгэй.

4.Мэргэжилтний багийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, ажлын явц, үр дүнг тухай бүр мэдээлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Жаргалмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ө.МӨНХ-АМГАЛАН



Сумын мэргэжилтэний багийн бүрэлдэхүүн

Багийн ахлагч	Д.Жаргалмаа (ИТХ-ын нарийн бичгийн дарга)
Нарийн бичгийн дарга	Э.Золжаргал (Сургуулийн нийгмийн бодлогын мэргэжилтэн)
Гишүүд	Ш.Нандиндэлгэр (Эрүүл мэндийн төвийн Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн) Б.Төгөлдөр (1 дүгээр багийн Засаг дарга) Г.Батчулуун (2 дугаар багийн Засаг дарга) Б.Наранбаатар (3 дугаар багийн Засаг дарга) Л.Батбаатар (4 дүгээр багийн Засаг дарга) Э.Ванчиндорж (Хэсгийн төлөөлөгч) М.Бат-Эрдэнэ (Хэсгийн Цагдаа)